



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn


᠑᠐᠒3.03.15 № ᠖42
танай _____-ны № _____-г

УЛААНБААТАР ЛИФТ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Д.ГАН-ЭРДЭНЭ ТАНАА

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2022 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, санал
дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 1. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ,
АУДИТОР *М.Эрдэнэжаргал* М.ЭРДЭНЭЖАРГАЛ



002032045



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2023/48/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	"Эс Жи Эм Ди-Аудит" ХХК	
	Захирал:	Д.Эхбаяр
	Утас: 70006948	Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn
	Аудитын менежер:	Д.Насанжаргал
	Утас: 70006948	Цахим хаяг: nasaa@sgmd-audit.mn
	Ахлах Аудитор:	О.Алтанцэцэг
	Утас: 70006948	Цахим хаяг: info@sgmd-audit.mn
	Аудитын шинжээч:	Ч.Ням-Очир
	Утас: 70006948	Цахим хаяг: c.nyamaa@sgmd-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МТА	Монголын татварын алба
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УБЗЗАГ	Улаанбаатар зам, засвар арчлалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023. 03. 15 № 643

танай _____ -ны № _____ -т

УЛААНБААТАР ЛИФТ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Д.ГАН-ЭРДЭНЭ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	58,175,078.00	314,882,874.00
1.1.4	Дансны авлага	4,015,000.00	51,214,471.01
1.1.6	Татвар НДШ-ийн авлага	106,623.06	1,115,365.73
1.1.7	Бараа материал	36,788,512.00	24,860,304.70
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	99,085,213.06	392,073,015.44
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	84,289,806.83	121,069,762.62
1.2.7	Биет бус хөрөнгө	15,833,820.00	15,833,820.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	100,123,626.83	136,903,582.62
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	199,208,839.89	528,976,598.06
2	Эргэлтийн бус хөрөнгө		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	58,175,078.00	314,882,874.00
2.1.1.4	ХАОАТ-ын өглөг		143,895.01
2.1.1.5	НӨАТ-ын өглөг		27,768,017.64
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	58,175,078.00	342,794,786.65
2.1.2.20	Өр төлбөрийн нийт дүн	58,175,078.00	342,794,786.65
2.2	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.2.1	Өмч : а) төрийн	69,938,295.00	69,938,295.00
2.2.4	Хувьцаат капиталын дүн	69,938,295.00	69,938,295.00
2.2.6	Дахин үнэлгээний нөөц	35,340,245.00	35,340,245.00
2.2.7	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	35,755,221.89	35,755,221.89
2.2.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)		45,148,049.52
2.2.20	Эзэмшигчдийн өмчийн дүн	141,033,761.89	186,181,811.41
2.3.20	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	199,208,839.89	528,976,598.06



2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	127,936,562.00	146,193,840.27
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)	127,936,562.00	146,193,840.27
8	Бусад орлого	1,015,160,592.00	1,657,223,442.64
10	Ерөнхий ба удирдлагын зардал	386,728,560.39	294,207,837.70
12	Бусад зардал	768,188,520.00	1,464,061,395.68
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(11,819,926.39)	45,148,049.52
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(11,819,926.39)	45,148,049.52
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(11,819,926.39)	45,148,049.52

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	69,938,295.00	35,340,245.00	47,575,148.28	152,853,688.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	69,938,295.00	35,340,245.00	(11,819,926.39)	(11,819,926.39)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	69,938,295.00	35,340,245.00	35,755,221.89	141,033,761.89
Залруулсан үлдэгдэл	69,938,295.00	35,340,245.00	35,755,221.89	141,033,761.89
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	45,148,049.52	45,148,049.52
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	69,938,295.00	35,340,245.00	80,903,271.41	186,181,811.41



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,144,392,154.00	2,174,597,420.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	129,231,562.00	150,223,377.00
	Татаас, санхүүжилтийн орлого	1,015,160,592.00	167,495,900.00
	Бусад мөнгөн орлого	-	1,856,878,143.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	442,997,128.00	592,255,667.00
	Ажиллагчдад төлсөн	120,468,630.97	229,018,086.14
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	49,815,989.23	27,841,800.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	102,055,949.00	6,851,914.66
	Ашиглалтын зардалд төлсөн	15,998,845.20	9,273,141.82
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,958,000.00	4,616,205.00
	Татварын байгууллагад төлсөн	12,847,444.80	-
	Даатгалын төлбөрт төлсөн	384,000.00	-
	Бусад мөнгөн зарлага	136,468,268.80	314,654,519.38
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	701,395,026.00	1,582,341,753.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	768,188,520.00	1,325,633,957.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	768,188,520.00	40,459,900.00
	Бусад	-	1,285,174,057.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(768,188,520.00)	(1,325,633,957.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(66,793,494.00)	256,707,796.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	124,968,572.00	58,175,078.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	58,175,078.00	314,882,874.00



2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	245,673,112.65	308,495,900.00	305,313,845.62	3,182,054.38	99.0
УРСГАЛ ЗАРДАЛ	245,673,112.65	308,495,900.00	305,313,845.62	3,182,054.38	99.0
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	245,173,112.65	307,995,900.00	305,113,845.62	2,882,054.38	99.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	184,239,217.45	225,612,500.00	229,018,086.14	(3,405,586.14)	101.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл	26,716,300.00	27,841,800.00	27,841,800.00	-	100.0
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	12,174,322.25	14,005,200.00	9,273,141.82	4,732,058.18	66.2
Хангамж бараа материалын зардал	9,156,782.95	12,361,600.00	11,468,119.66	893,480.34	92.8
Нормативт зардал	1,635,000.00	2,885,000.00	2,880,000.00	5,000.00	99.8
Эд хогшил, урсгал засварын зардал	4,132,500.00	18,949,700.00	17,634,600.00	1,315,100.00	93.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,618,990.00	6,340,100.00	6,998,098.00	(657,998.00)	110.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00	200,000.00	300,000.00	40.0
Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	500,000.00	500,000.00	200,000.00	300,000.00	40.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	249,647,362.00	308,495,900.00	305,313,845.62	3,182,054.38	99.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	120,415,800.00	167,495,900.00	155,090,468.62	12,405,431.38	92.6
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	129,231,562.00	141,000,000.00	150,223,377.00	(9,223,377.00)	106.5



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын зорилго нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргаас өгсөн чиглэл удирдамжийн дагуу Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй лифтийг шинэчлэх, техникийн болон магадлалын үйлчилгээ хийх, лифтний ашиглалт үйлчилгээний салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, гадаад дотоодын сургалтад хамруулах, ажилтнуудыг байнгын курсээр бэлтгэх, давтан сургах зэрэг боловсон хүчний нэгдсэн бодлого явуулах, ашиглалт засвар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулан ажиллах үндсэн зорилготой.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ статустай байна. Өмчийн 100 хувийг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал эзэмшиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2012 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2012 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/184 дүгээр захирамжийн дагуу 2012 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууц, барилга байгууламжийн лифтний ашиглалт засвар үйлчилгээнд хяналт тавих чиглэлээр байгуулсан байна.

Энэ нь ТБОНӨТХ-ийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;” гэсэн заалттай нийцэж байна.

Байгууллагын удирдлагыг Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэж байна.

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-т Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулаагүй байна.

Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10. “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд тайлант онд хөрөнгийн бүртгэл, ашиглалт хамгаалалтыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдсан



- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын удирдлагын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/34 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлдээ мөрдөж байна.

Тус ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцэж, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 283,879.2 мянган төгрөгөөр буюу 142.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	58,175.1	314,882.9	256,707.8
Авлага	4,121.6	6,441.3	2,319.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	36,788.5	24,860.3	(11,928.2)
Үндсэн хөрөнгө	100,123.6	136,903.6	36,780.0
Нийт хөрөнгө	199,208.8	483,088.0	283,879.2
Өр төлбөр	58,175.1	342,794.8	284,619.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	141,033.8	140,293.2	(740.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	199,208.8	483,088.0	283,879.2

Дээрх хүснэгтээс харахад тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгө өмнөх оноос 256,707.8 мянган төгрөгөөр буюу 5 дахин



өссөн байна. Энэ нь 271,111.2 мянган төгрөгийн барьцааг дансандаа байршуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 6,441.3 мянган төгрөг болж өмнөх оноос 2,319.6 мянган төгрөгөөр буюу 56.3 хувиар өссөн байна. Энэ нь ажилчидтай холбоотой болон төлбөртэй үйлчилгээний авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материал өмнөх оноос 11,928.2 мянган төгрөгөөр буюу 32.4 хувиар буурсан байна. Энэ нь сэлбэг хэрэгсэл 5,474.0 мянган төгрөг, түлш шатах тослох материал 4,758. мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх үндсэн хөрөнгө өмнөх оноос 36,780.0 мянган төгрөгөөр буюу 36.7 хувиар өссөн нь хандиваар болон худалдаж авсан эд хогшил, тоног төхөөрөмж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх өр төлбөр өмнөх оноос 284,619.7 мянган төгрөгөөр буюу 5 дахин өссөн байна. Энэ нь 314,882.9 мянган төгрөг андуурч орж ирснийг 2023 онд буцаан олгохоор бараа үйлчилгээний зардлын өглөг дансанд бүртгэсэн, НӨАТ төлөгч болсонтой холбоотойгоор 27,765.0 мянган төгрөгийн татварын өглөг бүртгэсэн нь тус тус нөлөөлсөн байна.

Эздийн өмч өмнөх оноос 740.5 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Улаанбаатар лифт ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/22 тоот захирамжаар Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 308,495.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 308,495.9 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 167,495.9 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 167,495.9 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 141,000.0 мянган төгрөгийн орлогыг төлөвлөснөөс 150,223.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж 305,313.9 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 12,405.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого гүйцэтгэл 150,233.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 9,233.7 мянган төгрөг буюу 6.5 хувиар нэмэгдсэн нь НӨАТ-ын 10.0 хувийг 9-12 дугаар сард нэмж тооцоноос шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 305.313.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 3,182.1 мянган төгрөг буюу 1.0 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь байр ашиглалтын зардал, шатахууны зардал дээр хэмнэлт үүссэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд үр дүнгийн тайлангаар 740.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Улаанбаатар лифт ОНӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудад өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Эс Жи Эм Ди Аудит ХХК-ийн аудитын менежер Д.Насанжаргал, ахлах аудитор Д.Жаргалсайхан, аудитор О.Ганчимэг, аудитын шинжээч Ч.Ням-Очир нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Оюунцэцэг, захирал Д.Эхбаяр, НТАГ-ын аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Эс Жи Эм Ди Аудит ХХК-д 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,154,917.1 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 23,098.3 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор даргын унаж байсан 64-09 УНР улсын дугаартай элентра маркийн автомашиныг Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2022 оны 12 дугаар 29-ны өдрийн №1/1541 албан бичиг болон даргын 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн №А/29 дугаар тушаалын дагуу, Нийслэлийн төр захиргааны авто баазад балансаас балансад шилжүүлсэн байна. Үүний үр дүнд тээвэр шатахууны зардлыг өмнөх оноос 556.7 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Мөн төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд шуудан, холбоо, интернэтийн төлбөр 327.7 мянга, цэвэр, бохир ус 544.3 мянга, байрны түрээс 2,404.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулж нийт 4,050.1 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал



АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд байршуулж мэдээлэх 509,367.8 мянган төгрөгийн 11 зарлагын гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 8,644.8 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 12,205.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээнүүдийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5. “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар мөнгөн хөрөнгө, дотоод хяналт, бараа материал, үндсэн хөрөнгө, худалдан авалт болон шилэн данстай холбоотой 11 зөрчил илэрч 9 зөвлөмж өгсөн. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 9 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 149,326.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 10,810.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснийг тус тус 100.0 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	149,326.8	2	149,326.8	100
Зөвлөмж	2	10,810.0	2	10,810.0	100
Нийт дүн	4	160,136.8	4	160,136.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл гараагүй 271,111.2 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын данснаас гүйцэтгэлийн баталгааны дансанд шилжүүлсэн асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 75,890.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийг 1,422.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг;

Үндсэн хөрөнгийн элэгдэл болон НӨАТ-ын залруулгуудаас шалтгаалж санхүүгийн үр дүнгийн тайланд нийт үр дүнг 28,579.4 мянган төгрөгөөр буруу илэрхийлснийг;

УБЗЗАГ ОНӨААТҮГ-т 45,888.6 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлснийг авлагаар бүртгүүлж залруулав;

Аудитаар нийт 47,835.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 7,904.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 39,931.9 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

Гэрээний дагуу 8 гэрээт ажилтанд олгосон 30,400.0 мянган төгрөгийн цалингаас 7,904.0 мянган төгрөгийн НДШ суутган тооцоогүй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1. "Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна." 32.1.2. "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс" заалтыг зөрчсөн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Бусад зардлын өглөг буюу гүйцэтгэлийн баталгааны 6,895.6 мянган төгрөгийн өглөг тооцоо нийлсэн актгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх;

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-2: Цахилгаан шатны засвар үйлчилгээний 7 гэрээт ажлын зураг төсвийн зохиогчийн хяналтын зардал 5,719.0 мянган төгрөгийг олгоогүй байгаа нь зохиогчийн хяналт хийгдээгүй гэж үзэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1. "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" заалттай нийцэхгүй,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Засвар үйлчилгээний зардалд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

3. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудал:

Илрүүлэлт-3: Эрх бүхий байгууллагын магадлалаар СХД-ийн 29 дүгээр хорооны 22А, 23Б, 23Г байруудад угсрагдсан 3ш лифтийг ашиглалтад оруулахад улсын байцаагчийн ашиглах зөвшөөрөл авахыг шаардсан боловч МХГ-аас зөвшөөрсөн тухай акт байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална” 5.1.4. “үнэн зөв байх;” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Лифт угсралтын ажилд мэргэжлийн байгууллагуудын магадлал, зөвшөөрлийг авах, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах

Илрүүлэлт-4: Тайлант оны захиалагчийн хяналтын ажлын 9,960.2 мянган төгрөгийн орлогод төлбөрийн баримт шивээгүй, харилцагч “Оакс экспресс Монголиа” ХХК-д шилжүүлсэн 860.5 мянган төгрөгийн 2 удаагийн и-баримт 2023 онд шивэгдсэн байна. Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 “албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ;” заалтыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: НӨАТ-ын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, харилцагч байгууллагаар төлбөрийн баримтыг бүрэн бүртгүүлж байх.

Илрүүлэлт-5: Татварын байгууллагаар баталгаажсан татварын үлдэгдлээс ХХОАТ-ын өглөг 1,953.2 мянган төгрөг, НӨАТ-ын авлага 3,875.0 мянган төгрөгийн зөрүүтэй, УБЗЗАГ-т НӨАТ төлөгч болохоос өмнөх буюу 2021 оны 9,807.6 мянган төгрөгийн НӨАТ багтсан гүйлгээг шивсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, НӨАТ-ын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 “Албан татвар суутган төлөгчийн борлуулалтад албан татвар ногдуулах хугацааг татварын албанаас гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн тооцно.” заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НӨАТ-ын тухай хуулиудыг хэрэгжүүлж ажиллах, НӨАТ-ын авлага, өглөгийн гүйлгээг тухай бүр хянан баталгаажуулж бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн	1	1,422.8			1	1,422.8	1	1,422.8		
Нийт үр дүнг буруу илэрхийлсэн	1	28,579.4			1	28,579.4	1	28,579.4		
Авлага бүртгээгүй	1	45,888.6	1	45,888.6			1	45,888.6		
Дүн	3	75,890.3	1	45,888.6	2	30,002.2	2	75,890.8	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Цахилгаан шатны засвар үйлчилгээний 7 гэрээт ажлын зураг төсвийн зохиогчийн хяналтын зардал олгоогүй нь зохиогчийн хяналт хийгдээгүй.	1	5,719.0			1	5,719.0
НДШ-ийг суутган тооцоогүй	1	7,904.0	1	7,904.0		
Эрх бүхий байгууллагын магадлалаар лифтийг ашиглалтад оруулахад улсын байцаагчийн ашиглах зөвшөөрөл авахыг шаардсан боловч МХГ-аас зөвшөөрсөн тухай акт байхгүй.	1	-			1	-
Бусад зардлын өглөг буюу гүйцэтгэлийн баталгааны өглөг тооцоо нийлсэн актгүй.	1	6,895.9			1	6,895.9
Цахим И баримтаар баталгаажаагүй	1	11,681.2			1	11,681.2
Татварын байгууллагаар баталгаажсан татварын үлдэгдлээс ХХОАТ-ын өглөг, НӨАТ-ын авлага зөрүүтэй.	1	15,635.8			1	15,635.8
Дүн	6	47,835.9	1	7,904.0	5	39,931.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/


Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансанд байршуулж мэдээлэх 509,367.8 мянган төгрөгийн 11 зарлагын гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 8,644.8 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 12,205.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээнүүдийн мэдээлээгүй байна.	1	530,218.0			1	530,218.0
Дүн	1	530,218.0	-	-	1	530,218.0

АУДИТЫН ТАЙЛАНГ

УЛААНБААТАР ХОТ

ХЯНАСАН:


“ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ” ХХК-ийн
ЗАХИРАЛ



Д.ЭХБАЯР


БЭЛТГЭСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.НАСАНЖАРГАЛ

АУДИТЫН ШИНЖЭЭЧ



Ч.НЯМ-ОЧИР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023. 03. 15

№

675

танай

-ны №

-г

УЛААНБААТАР ЛИФТ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Д.ГАН-ЭРДЭНЭ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар илэрсэн зөрчилд 7,904.0 мянган төгрөгийн албан шаардлагыг хүргүүлж байна.

Албан шаардлагыг заасан хугацаанд хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002032137



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 265/22310594

Улаанбаатар хот

УТЖ-2023/48/НА-СТА-ОНА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрээт ажлын цалингаас 7,904,000.00 (долоон сая есөн зуун дөрвөн мянга) төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1. "Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна:" 32.1.2. "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс" заалтыг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар лифт ОНӨААТҮГ-ын дарга Д.Ган-Эрдэнэ, ахлах нягтлан бодогч З.Ариунтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

"ЭС ЖИ ЭС ДИ АУДИТ" ХХК ИЙН
ЗАХИРАЛ

ХЯНАСАН

Д.ЭХБАЯР

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР

З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г.корпус, 4 давхар

002042133